



Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл

Сэтгүүл: 2017 оны 1 сар

ТӨСЛИЙН ТУХАЙ

Канад Улсын Гадаад Хэргийн Газраас санхүүжүүлж буй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах” (MERIT) Төсөл нь олборлох салбарыг үр дүнтэй удирдахад төрийн байгууллагууд болон орон нутгийн холбоодын чадавхийг бэхжүүлэх замаар Монгол дахь тогтвортой эдийн засгийн өсөлтийг сэргээхэд хувь нэмрээ оруулна.

Төслийн үйл ажиллагаануудын нэг чухал хэсэг нь уул уурхайн нөлөөлөлд автсан аймаг, сумдыг сонгон ажиллахдаа нутгийн иргэдэд орлого олох боломжийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхээс гадна, бүх түвшиний төрийн байгууллага, орон нутгийн холбоодын бүтээлч, үр өгөөжтэй хамтын ажиллагааг дэмжихэд оршино.



Төслийн Удирдах Зөвлөлийн эхний уулзалт, 2016.08.30

Төсөл нь дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж байна:

- Уул уурхайн гол стратегийн байгууллагуудын менежментийн чадавхи болон хамтын ажиллагааг сайжруулах (УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, УУҮА)
- Уул уурхай дахь төрийн байгууллагууд (төвийн болон аймаг, сумдын түвшний), иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн холбоодын үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Сургалтын байгууллагуудтай хамтрах замаар олборлох салбарт хувь дэмжлэг үзүүлж буй төрийн сургалтын байгууллагуудын чадавхийг сайжруулах (ШУАГТХ, МУШУТИС)

Энэхүү төсөл нь Канадын Мэргэжлийн Үйлчилгээний Байгууллага (КМУБ) болон Канадын Дэлхийн Их Сургуулийн Үйлчилгээ (КДИСУ) гэх Канадын 2 төрийн бус байгууллагын консорциум юм.

Канадын Мэргэжлийн Үйлчилгээний Байгууллага (КМУБ) нь сайн дурынхныг ажиллуулдаг Канадын тэргүүлэх хөгжлийн байгууллага юм. Тус байгууллага нь өндөр туршлагатай Техникийн Зөвлөхүүд (ТЗ)-ийн тусламжтай тогтвортой эдийн засаг, нийгмийн өсөлтийг Канад болон дэлхий дахинд бий болгох зорилгоор 1967 онд

байгуулагдсан билээ. КМУБ нь хамтын ажиллагаа нь ядуурлыг бууруулах, эрүүл, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, иргэдийн амьдралд бодит өөрчлөлт авчрах гол хүчин мөн гэдэгт бат итгэдэг баг хамт олноос бүрдсэн.

Канадын Дэлхийн Их Сургуулийн Үйлчилгээ (КДИСУ) нь боловсрол болон сургалтаар хүний хөгжлийг дэмжих, дэлхий нийтийн ойлголтыг сайжруулах зорилго бүхий Канадын тэргүүлэх хөгжлийн агентлаг ба 1920 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй. КДИСУ нь амьдралын боломж муутай залуусд дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн, оюутнууд, сайн дурынхан, багш сурган хүмүүжүүлэгч, орон нутгийн удирдагч нараас бүрдсэн сүлжээ байгууллага юм. КДИСУ нь дэлхийн хамтрагч байгууллагууд болох засгийн газар, иргэний нийгэмлэг болон хувийн салбарынханд дэмжлэг үзүүлэхээр урт хугацааны сайн дурынхан илгээдэг.

ЭХНИЙ ЖИЛ

Уул уурхайн засаглалыг сайжруулах нь Монгол Улсын Засгийн Газрын нэн тэргүүлэх зорилтуудын нэг бөгөөд энэхүү төсөл нь засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөртэй уялдаж байгаагаараа онцлог юм. Тухайлбал, энэ төсөл нь уул уурхайн салбарын тогтвортой, ил тод хөгжлийг дэмжинэ.

Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнүүд

Төсөл нь уул уурхайн гол стратегийн байгууллагуудын болон сургалтын газруудын Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнүүд боловсруулахаар Канадын туршлагатай Техникийн Зөвлөхүүдийг урин ажилуулж байна. Эдгээр төлөвлөгөөнүүд нь боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхэд зааварчилгаа өгөн, бодлого, дүрэм журам, үйл ажиллагааны шат дамжлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мониторинг хийх чадвар бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэх мөн агентлаг хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулахад зөвлөнө. Мөн эдгээр төлөвлөгөөнүүд нь төрийн байгууллагууд, орон нутгийн холбоод, салбарынхны мэдээлэл хуваалцах болон үр өгөөжтэй уулзалтууд зохион байгуулах арга замыг нэгтгэн оруулсан байгаа.



БОАЖЯ-ны Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөөнд Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл болон төслийн захирал Синди Фэйр нар гарын цсэг зурах цэр

- Ашигт Малтмал Газрын Тосны Газрын (АМГТГ) Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөө нь 2016 оны 5-р сарын 25-нд батлагдсан.
- Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны (БОАЖЯ) Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөө нь 2016 оны 11-р сарын 26-нд батлагдсан.
- Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яамны (УУХҮЯ) Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөө нь 2016 оны 12-р сарын 09-нд батлагдсан.

Чадавхи хөгжүүлэх ажиллагаанууд

2016 оны 9-р сараас 2017 оны 1-р сарын хооронд хэрэгжсэн сургалтууд:

- Эхний арга хэмжээ нь “Газрын тосны хайгуул ба бүтээгдэхүүн хуваах гэрээ” сэдвээр нийт 49 албан хаагчдад хийсэн танилцуулга байв. Танилцуулгыг 2016 оны 7-р сарын 17-ноос 30-ны хооронд Канад улсад зохиогдсон Удирдлагын Хөгжлийн Хөтөлбөрт хамрагдсан АМГТГ-ын мэргэжилтэн хийсэн болно.
- Түүний хоёр дахь танилцуулга “Канадын газрын тосны салбарын хууль эрх зүйн орчин, салбарын үйл ажиллагааны зохицуулалт” сэдвээр хийгдэв.
- Төсөл нь мөн Канадын Спрол буюу Дэлхийн Газрын Тосны Зөвлөх байгууллагатай хамтран 10-р сарын 27-нд АМГТГ-ын удирдах ажилтнуудад “Байгалийн нөөц баялгийн удирдамж ба хууль дүрэм” сэдвээр цахим сургалтыг амжилттай зохион байгуулав.
- Канад Улсын Гадаад Хэргийн Газрын Зүүн Хойд Ази ба Номхон Далайн Бүс Газрыг хариуцсан Дэд Захирал, Канадын Элчингийн Нэгдүгээр Нарийн Бичиг болон Худалдааны Төлөөлөгч зэрэг нийт 23 хүн төслийн зөвлөхийн “Мэдээллийн портал – бидний мэдээллээ авах нэг цэг” сэдвээр хийгдсэн танилцуулга арга хэмжээнд хамрагдсан. Мэдээллийн портал гэдэг нь MERIT болон SE-SMIM төслүүдээс боловсруулан гаргасан англи, монгол хэл дээрхи мэдээллийн бүтээгдэхүүнүүдийг хадгалах систем юм.



2016 оны 11-р сарын 30-ны “Мэдээллийн портал – бидний мэдээллээ авах нэг цэг” сургалтын цээр

- Төсөл нь Канадын Спрол буюу Дэлхийн Газрын Тосны Зөвлөх байгууллагатай хамтран 2017 оны 01-р сарын 9-ноос 27-ны хооронд АМГТГ-ын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага болон бусад яамдын төлөөлөгч нарт “Байгалийн нөөц баялгийн ангилалын систем ба хуулийн орчин” сэдвээр танхимийн сургалтыг зохион байгуулж дуусгав. Сургалтанд

оролцогч нар үндэсний нөөц баялгийн ангилалын системийн талаар өөрсдийн санал бодлоо хуваалцсанаар өндөрлөв.



Оролцогч нар Спрол сургалтын сертификат авав. 2017.01.12

Хийгдэж буй ажлууд



Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн их сургууль дээр ажилласан Төслийн ТЗ, Пам Патен

Төслийн Техникийн Зөвлөх нь мэргэжлийн хүмүүстэй уулзалт зохион байгуулах, холбогдох мэргэжилтнүүдээс судалгаа авах зэргээр мэдээллээ цуглуулан Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Уул Уурхай Геологийн Танхимийн Чадавхи Хөгжүүлэх Төлөвлөгөөг боловсруулсан.

Төслийн Техникийн Зөвлөх нь Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-Геоэкологийн Хүрээлэнгийн Чадавхи Хөгжүүлэх Төлөвлөгөө болон стратегийн төлөвлөгөөг боловсруулахаар хэдэн долоо хоног ажилласан.

Төслийн Техникийн Зөвлөх нь Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн гишүүд болон харилцагч нартай мөн бусад төрийн болон олон улсын байгууллагууд уул уурхайн компанийн мэргэжилтэнүүдтэй уулзалт хийн мэдээллээ цуглуулан Чадавхи Хөгжүүлэх Төлөвлөгөө болон стратегийн төлөвлөгөөг нь боловсруулж өгсөн.

- Төрийн байгууллагад зөвлөгөө өгөх ТЗ: УУХҮЯ
- Өөрчлөлтийн менежментийн ТЗ: УУХҮЯ

ОЙРЫН ҮЕД ХИЙГДЭХ АЖЛУУД

- Мэдээлэл, харилцаа холбооны ТЗ: УУХҮЯ
- Жендерийн эрх тэгш байдлын ТЗ: УУХҮЯ
- Хяналт ба үнэлгээний ТЗ: БОАЖЯ
- Мэдээлэл, харилцаа холбооны ТЗ: БОАЖЯ
- GIS системийн ТЗ: ШУАГГХ
- Хүний нөөцийн ТЗ: АМГТГ
- 2017-2018 оны ажлын төлөвлөгөөг боловсруулах
- Аймгийн түвшний ажлуудыг судлах

Бидэнтэй холбоо барих:

“Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах” (MERIT) Төсөл, 3 давхар, Нейшнл Таймс Ньюс Тауер, Худалдааны гудамж, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7610-5000, Цахим хаяг: support@merit.mn,

Санал хүсэлт байвал бидэнтэй холбогдоно уу.